



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
өргөн мэдүүлсэн

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ ШҮҮМЖ**

ГЭРЭГЭ БОДЛОГЫН ХҮРЭЭЛЭН

Боловсруулсан:

Х.Номингэрэл

Б.Эрдэнэбулган

Р.Мөнхзул

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2026 оны 3 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн "Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл парламентын гишүүнд хариуцлага тооцох байдлаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох буюу "эгүүлэн татах" харилцааг зохицуулах зорилготой байна. Энэ хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан эгүүлэн татахтай холбоотой зохицуулалтад бүрнээ нийцэх учиртай.

Энэхүү хуулийн төсөл нь парламентын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой гэх боловч Үндсэн хууль, түүний суурь зарчмуудтай зөрчилдөж, УИХ-ын төлөөллийн мөн чанар, парламентын бүрэн эрхт байдал, гишүүний чөлөөт мандатад халдсан шинжтэй байна.

Ялангуяа намын жагсаалтаар сонгогдсон гишүүнийг нам, эвслээс эгүүлэн татах санал гаргаж шийдвэрлэх нь гишүүний ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах зарчмыг зөрчиж, гишүүдийн тэгш байдлыг алдагдуулж байна. Мөн иргэний гомдлын дагуу ёс зүйн ноцтой зөрчил гаргасан, тангаргаасаа няцсан зэрэг ерөнхий үндэслэлүүдээр УИХ-аас эгүүлэн татах үндэслэл байгаа эсэхийг Цэцээр тогтоолгохоор УИХ-аас хүсэлт явуулах заалтууд нь Үндсэн хуульд байхгүй шинэ зохицуулалт үүсгэсэн, нөгөө талаар мөн гишүүний чөлөөт мандатыг зөрчиж байна.

Түүнчлэн УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосноос бусад тохиолдолд буюу Цэцээс гаргасан дүгнэлтүүдийг УИХ-д танилцуулснаар орон гарсан гэж үзэж гишүүнийг эгүүлэн татан тухай тогтоол баталсанд тооцно гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 29.3-т заасан Улсын Их Хурлаас дүгнэлтэд үндэслэн эгүүлэн татах эсвэл бусад хэлбэрээр эцэслэн шийдвэрлэх бүрэн эрхэд халдаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ШҮҮМЖ

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан эрх мэдэл хуваарилах зарчим, парламентын бие даасан байдал, гишүүний халдашгүй байдал, чөлөөт мандатын зарчим зэрэг нь төлөөллийн ардчилал, парламентын засаглалын амин сүнс юм. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2026 оны 3 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн "УИХ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл парламентын гишүүнд хариуцлага тооцох байдлаар УИХ-ын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох буюу "эгүүлэн татах" механизмыг нарийвчлан зохицуулах зорилготой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 23-р зүйлд Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална, 21-р зүйлд УИХ-ын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно зэрэг заалтуудыг үндэслэн Үндсэн хуульд парламентын гишүүний чөлөөт мандатын зарчмыг баримталсан гэж эрх зүйн онолын хувьд үздэг.

Чөлөөт мандат нь төлөөллийн ардчиллын суурь зарчим бөгөөд парламентын гишүүд улсын, нийт иргэдийн эрх ашигт тулгуурлан бие даан шийдвэр гаргах эрхтэй байдаг. Харин **императив/захирагдах мандат** нь төлөөлөгчийг нэр дэвшүүлсэн нам эсвэл сонгосон сонгогчид, тодорхой бүлгийн хүсэл зориг, чиглэлд захирагдахыг ойлгодог. Ардчилсан улс орнуудад чөлөөт мандатын зарчмыг ихэвчлэн дагадаг бөгөөд Үндсэн хуульдаа тусгайлан тусгах, эсвэл императив мандатыг хориглосон байдлаар илэрхийлдэг.

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөл нь энэхүү суурь зарчмыг хөндөж, иргэдээс мандатаа авсан гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох харилцааг зохицуулж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон парламентын тухай үзэл баримтлал, чөлөөт мандатын зарчимтай нийцэж байгаа эсэхэд анхааралтай хандах ёстой.

Нэг. УИХ-ын гишүүний бүрэн эрхийг хариуцлага тооцох замаар дуусгавар болгох Үндсэн хуулийн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 29.3-т УИХ-ын гишүүний бүрэн эрх хариуцлага тооцох байдлаар хугацаанаасаа өмнө дуусгавар болох үндэслэлүүдийг тодорхойлсон байна. Үүнд:

- УИХ-ын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол эгүүлэн татах үндэслэл болно (Энэ хэсэг 2019 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлтөөр орсон).
- УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

Өөрөөр хэлбэл, УИХ-аас гишүүнийг "эгүүлэн татна" гэж ойлгомжтой, хоёрдмол утгагүй томъёолсон буюу Үндсэн хуулийн 29.3-т заасан ". . . уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна" гэжээ. Харин "УИХ-ын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол эгүүлэн татах үндэслэл болно" гэж томъёолсныг анхаарах шаардлагатай.

Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн 66-р зүйлийн 2-т Цэцийн харьяалалд хамаарч, дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж, УИХ-д оруулахаар заажээ. Үүнд:

- 66.2.3/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, **гишүүн**, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор **Үндсэн хууль зөрчсөн эсэх**;
- 66.2.4/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, **Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх**.

Үндсэн хуулийн дээрх зохицуулалтаас үзэхэд:

- **“эгүүлэн татах үндэслэл болно”;**
- **“эгүүлэн татна”;**
- **“эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх”** гэсэн агуулгууд байна.

Харин Үндсэн хуульд УИХ-ын гишүүнийг эгүүлэн татахад УИХ-тай холбоотой дараах зохицуулалт байна. Үүнд:

- **Улсын Их Хурал** түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.
- **Улсын Их Хуралд** [Цэц] оруулна гэсэн томъёоллууд байна.

Нэгтгэн дүгнэвэл, УИХ-ын гишүүнийг гарцаагүй эгүүлэн татах, эсхүл гишүүнийг эгүүлэн татах эсэхийг УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд хэлэлцэн шийдвэрлэх гэсэн хоёр хэлбэрийн нөхцөл, журмыг Үндсэн хуулиар зохицуулсан байна.

Гишүүнийг эгүүлэн татах нөхцөл нь өмнө дурдсанаар Үндсэн хуулийн 29.3-т заасан “ . . . уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэсэн заалт бөгөөд зөвхөн энэ тохиолдолд УИХ гишүүнийг шууд эгүүлэн татахаар байна.

Бусад тохиолдолд гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг УИХ хэлэлцэн шийдвэрлэх агуулгатай байна. Үүнд:

1. **Үндсэн хуулийн 29.3:** “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно”, Үндсэн хуулийн 66.2.3-т “. . . Улсын их хурлын дарга, гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна”, 66.2.4-т “. . . Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна” гэсэн УИХ-ын гишүүнийг заавал эгүүлэн татна гэсэн үүрэг болгосон заалт биш байна. Тодруулбал, “үндэслэл болно”, “. . . дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна” гэсэн нь тухайн гишүүнийг эгүүлэн татах эсэхийг Улсын Их Хурал хэлэлцэн бие даан шийдвэрлэх агуулгатай байна.
2. **Үндсэн хуулийн 66.2.3, 66.2.4-т** заасан Цэцийн дүгнэлтүүд нь Үндсэн хуулийн 29.3-т заасан гишүүн Үндсэн хууль зөрчсөн үндэслэл байгаа эсэх маргаантай асуудлыг харьяалж дүгнэн, УИХ-д оруулах процедурын шинжтэй байна.

УИХ-ын тухай хууль тогтоомжид энэ асуудлыг дараах байдлаар зохицуулсан байдаг. Тухайлбал, УИХ-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т Үндсэн хуулийн 66.2.4 буюу УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрсөн бол эгүүлэн татах тогтоол гаргана. Мөн УИХ-ын тухай хуулийн 9.3-т ҮХЦ-ээс УИХ-ын гишүүнийг тангаргаасаа няцаж Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг УИХ хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах асуудлыг УИХ хэлэлцэн шийдвэрлэнэ гэжээ. Өөрөөр хэлбэл Цэцээс “гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй” гэж дүгнэлт гаргасныг УИХ хүлээн зөвшөөрвөл эгүүлэн татах тухай тогтоол гаргана. Харин Цэцээс гишүүн “Үндсэн хууль зөрчсөн” гэсэн дүгнэлт ирүүлснийг УИХ зөвшөөрвөл түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг УИХ цааш хэлэлцэн шийдвэрлэхээр байна.

Үндсэн хуулийн цэцэд УИХ-ын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар 1994 онд 3 маргааныг үүсгэн шийдвэрлэж байжээ. Түүнээс хойш хувь гишүүнийг Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг 2025 оны 10-р сард 1 удаа өөр маргаантай нэгтгэн хэлэлцэж, Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэжээ. 1994 онд шийдвэрлэсэн 3 маргааны хоёр удаагийн тохиолдолд нэр бүхий УИХ-ын гишүүн нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлтийг УИХ-д оруулсан байна. Ингэхдээ Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-т заасан "Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" тухай заалтыг үндэслэн тухайн 2 гишүүнийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн байна. Өөрөө хэлбэл Үндсэн хуульд хувь гишүүнд хамаатуулан тусгайлан хориглосон заалтыг зөрчсөн тул Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн байна.

Хоёр. Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийн шинжилгээ

Ерөнхийлөгчийн өргөн барьсан төсөл нь үндсэндээ УИХ-ын гишүүний бүрэн эрхийг хариуцлага тооцох байдлаар хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг Үндсэн хуульд заасан "тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн байх" болон "гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосон бол" гэсэн 2 үндэслэлээс өргөжүүлж, 3 үндэслэл нэмсэн гэж үзэж болохоор байна. Мөн хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар жагсаалтаар сонгогдсон гишүүнийг улс төрийн намаас эгүүлэн татах тусгайлан зохицуулалт шинээр бий болгосон. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцээс эдгээр асуудлаар гаргасан дүгнэлтүүд болон гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосон тохиолдолд УИХ-аас дүгнэлтийг зөвшөөрөх болон эгүүлэн татах эсэх асуудлаар УИХ хэлэлцэн шийдвэрлэх процесст өөрчлөлт оруулж, дүгнэлтүүдийг УИХ-д танилцуулсан, хүргүүлсэн бол гишүүнийг эгүүлэн татах тухай тогтоол баталсанд тооцно гэж тусгажээ. Эдгээрийг нарийвчлан тайлбарлавал:

1. Төслийн 1.2 дах заалтад УИХ-ын тухай хуулийн 9.1.6-т намын жагсаалтаар сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь "ёс зүйн ноцтой зөрчил гаргасан" гэж үзвэл эгүүлэн татах саналаа УИХ-д гаргаж, уг саналыг УИХ нээлттэй хэлэлцэн, илээр санал хурааж шийдвэрлэх заалтыг нэмж оруулахаар тусгажээ. Монгол Улсын Үндсэн хуульд парламентын гишүүдийн хэрхэн сонгогдсоноос үл хамааран чөлөөт мандаттай, ижил бүрэн эрхтэй байх бөгөөд хэрхэн сонгогдсоноор нь ялгамжтай зохицуулах, хариуцлагын өөр өөр тогтолцоо байхгүй. Мөн сонгуулийн холимог тогтолцоотой орнуудад ч ийм жишиг байхгүй байна.

Намын жагсаалтаар сонгогдсон гишүүнийг харьяалах нам нь "ёс зүйн зөрчил гаргасан" үндэслэлээр эгүүлэн татах санал гаргах нь гишүүний ард түмний биш, намын төлөөлөл гэх үзэлд тулгуурласан байх бөгөөд намаас, түүний удирдлагаас хамааралтай, хараат байдалд оруулж, намынхаа бодлого, байр суурьтай зөрчилдсөн гишүүнийг зайлуулах хэрэгсэл болгон ашиглах эрсдэлтэй байна. Ингэснээр Үндсэн хуулиар хамгаалсан гишүүний бүрэн эрх, ард түмний элч байх мандатыг үгүйсгэжээ. Түүнчлэн зарим гишүүдийг Үндсэн хуульд заагаагүй үндэслэлээр эгүүлэн татах боломжийг нээж байгаараагаа Үндсэн хуулийн зөрчил үүсгэнэ.

2. Төслийн 1.3-т УИХ-ын тухай хуулийн 9.2-т УИХ-ын гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох тухай Үндсэн хуулийн бус үндэслэлүүд, процедурыг нэмж тусгажээ. Төсөлд "Энэ зүйлийн 9.1.5-д заасан хүсэлтийг Улсын Их Хурал гаргахдаа дараах асуудлаар гаргасан иргэний гомдлыг үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо урьдчилан хянан үзэж, үндэслэл бүхий хэмээн үзвэл дэд хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцэж, илээр санал хураан Улсын Их Хурлын гишүүдийн олонхын саналаар дэмжсэн байна:

9.2.1.Гишүүн өргөсөн тангарагаасаа няцсан;

9.2.2.Ард түмний элчийн хувьд гишүүн нь төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлээгүй буюу Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй;

9.2.3.Гишүүн нь хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлээгүй буюу Улсын Их Хурлын ээлжит чуулганы санал хураалтын 30-аас дээш хувьд биечлэн оролцоогүй;

9.2.4.Гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн.

Төслийн энэ хэсэгт заасан “хүсэлт” нь төслийн 9.1.5-д байхгүй, ямар хүсэлт хэлж байгаа нь ойлгомжгүй байна. Төслийн Дэлгэрэнгүй танилцуулгад тусгасан тайлбараас харвал УИХ-аас гишүүнийг эгүүлэн татах тухай маргаантай асуудлаар дүгнэлт гаргуулахаар Цэцэд хүсэлт явуулахтай холбоотой процедур, үндэслэлийг заасан байна гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл Үндсэн хуульд заагаагүй шинэ төрлийн эгүүлэн татах үндэслэл, процедурыг үүсгэж байна.

Нөгөө талаар энд заасан тангарагаасаа няцсан, ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн зэрэг нь гишүүний бүрэн эрхийг хязгаарлахад хэт ерөнхий, тодорхойгүй томъёоллууд бөгөөд улс төрийн ашиг сонирхол, намчирхлын үүднээс үзэмжээр тайлбарлаж хэрэглэх, ард түмнээс мандат авсан гишүүний эрхэд халдаж, иргэдийн төлөөлүүлэх сонголтыг үгүйсгэх эрсдэлтэй байна.

3. УИХ-ын тухай хуулийн 9.1.4 ба 9.2-т зааснаар Цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэж дүгнэлт гаргасныг УИХ хүлээн зөвшөөрвөл эгүүлэн татах тогтоол гаргана. Мөн 9.3-т зааснаар гишүүн тангарагаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт Цэц гаргасныг УИХ хүлээн зөвшөөрвөл түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг УИХ хэлэлцэн шийдвэрлэхээр байгаа билээ.

Гэтэл Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөлд энэхүү УИХ хүлээн зөвшөөрөх, өөрөө хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг дордуулан Цэцийн 2 төрлийн дүгнэлтийг “УИХ-д танилцуулснаар орон гарсан гэж үзэж гишүүнийг эгүүлэн татан тухай тогтоол баталсанд тооцно” гэж шууд үйлчлэх зохицуулалт тусгажээ.

Өөрөөр хэлбэл, УИХ Цэцийн дүгнэлтийг сонсож танилцсанаар ямар нэг нэмэлт хэлэлцүүлэг, санал хураалтгүйгээр тухай гишүүнийг шууд эгүүлэн татсанд тооцох үр дагавартай болсон байна. Үндсэн хуулийн холбогдох заалтуудын агуулгыг өмнөх хэсэгт тайлбарласнаар эдгээр “Үндсэн хууль зөрчсөн”, “эгүүлэн татах үндэслэл байгаа” гэсэн Цэцийн дүгнэлтүүд нь шууд эгүүлэн татах үр дагавар үүсгэхгүй, энэ талаар УИХ өөрөө хэлэлцэн эцсийн шийдвэр гаргах эрхтэй байна. Тухайлбал Үндсэн хуулийн 29.3 заалт нь УИХ-д хандсан шинжтэй зохицуулалт бол 66-р зүйл нь Цэцээс эдгээр асуудлаар дүгнэлт гаргаж УИХ-д шийдвэрлүүлэхээр оруулах тухай зохицуулалт юм.

Цэцийн 1994 оны 03, 06 тоот дүгнэлтүүдэд ч тухайн гишүүдийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн ч эгүүлэн татаагүй бөгөөд гишүүд бүрэн эрхээ цаашид хэрэгжүүлсэн байдаг.

Иймд Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөлд туссан агуулгаар буюу Цэцийн дүгнэлтийг “УИХ-д танилцуулснаар орон гарсан гэж үзэж гишүүнийг эгүүлэн татах тухай тогтоол баталсанд тооцох” нь Үндсэн хуульд заасан УИХ өөрөө хэлэлцэн шийдвэрлэх эрхийг үгүйсгэж, УИХ-ын бүрэн эрх, гишүүний чөлөөт мандат, халдашгүй байдалд халдсан хэрэг юм.

4. Үндсэн хууль болон УИХ-ын тухай хуулиар гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоосон бол УИХ түүнийг эгүүлэн татах тогтоол гаргах зохицуулалттай. Энд УИХ-аас ямар нэг зөвшөөрөх эсвэл хэлэлцэн шийдвэрлэх зохицуулалт байхгүй. Хуулийн төсөлд "...шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж УИХ-ын даргад хүргүүлсэн" гэж нэмсэн нь тухайн харилцааг бүрэн зохицуулсан гэж үзэх боломжгүй.

5. Бусад заалтууд:

Төслийн 2 дугаар зүйлд УИХ-ын гишүүний тангарагт "ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж" гэсэн өгүүлбэрийг нэмсэн байна. Энэ нь Үндсэн хуулийн 29.3-т "тангаргаасаа няцвал" гэсэн агуулгад ёс зүйн зөрчлийг багтаах зорилготой гэж ойлгохоор байна. Ийнхүү ёс зүйн хэм хэмжээ нь гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсвэл эгүүлэн татах үндэслэл болж, бүрэн эрхийг дуусгавар болгох нөхцөлийг үүсгэхээр байна.

Түүнчлэн тус хуулийн төслийг дагалдаж Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад оруулж буй нэмэлт өөрчлөлтүүд нь эдгээр хуулиудын зохицуулах харилцаанаас хэтрүүлж, УИХ-ын гаргах шийдвэрийг тусгасан байгаа нь хууль зүйн техникийн хувьд алдаатай, цаашлаад УИХ-ын бүрэн эрхэд халдсан байна.

ДҮГНЭЛТ

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь парламентын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой гэх боловч Үндсэн хууль, түүний суурь зарчмуудтай зөрчилдөж, УИХ-ын төлөөллийн мөн чанар, парламентын бүрэн эрхт байдал, гишүүний чөлөөт мандатад халдсан шинжтэй байна.

Ялангуяа намын жагсаалтаар сонгогдсон гишүүнийг нам, эвслээс эгүүлэн татах санал гаргаж шийдвэрлэх нь гишүүний ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах зарчмыг зөрчиж, гишүүдийн тэгш байдлыг алдагдуулж байна. Мөн иргэний гомдлын дагуу ёс зүйн ноцтой зөрчил гаргасан, тангаргаасаа няцсан зэрэг ерөнхий үндэслэлүүдээр УИХ-аас эгүүлэн татах үндэслэл байгаа эсэхийг Цэцээр тогтоолгохоор УИХ-аас хүсэлт явуулах заалтууд нь Үндсэн хуульд байхгүй шинэ зохицуулалт үүсгэсэн, нөгөө талаар мөн гишүүний чөлөөт мандатыг зөрчиж байна.

Түүнчлэн УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосноос бусад тохиолдолд буюу Цэцээс гаргасан дүгнэлтүүдийг УИХ-д танилцуулснаар орон гарсан гэж үзэж гишүүнийг эгүүлэн татан тухай тогтоол баталсанд тооцно гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 29.3-т заасан Улсын Их Хурлаас дүгнэлтэд үндэслэн эгүүлэн татах эсвэл бусад хэлбэрээр эцэслэн шийдвэрлэх бүрэн эрхэд халдаж байна.

ГЭРЭГЭ БОДЛОГЫН ХҮРЭЭЛЭН НЬ БОДЛОГО БОЛОВСРУУЛАХАД ЗӨВЛӨХ, СУДАЛГАА ХИЙХ, НАМЫН ГИШҮҮДИЙГ СУРГАЖ БЭЛТГЭХ, ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ҮҮРЭГ БҮХИЙ АРДЧИЛСАН НАМЫН ДЭРГЭДЭХ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГА ЮМ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих

- 📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу-1, Ардчилсан намын байр.
- ✉ info@geregethinktank.mn
- 📘 Гэрэгэ бодлогын хүрээлэн / Gerege think tank